

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/26/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 51- 261628 Цахим хаяг: enkbaatare@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1135

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 58.3 сая төгрөгөөр давсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүний эрхийн үндэсний комисс нь Олон улсын байгууллагуудаас 313.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 9 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх

чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж, хяналт шинжилгээ, судалгаа боловсруулж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн асуудлаарх өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1211 хүнд 390 цагийн хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд стратегийн 7 зорилго, 36 зорилтын хүрээнд 125 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93.8 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	376,951.4	321,011.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,054.2	116,254.2
33	АВЛАГА	195,066.5	107,614.1
34	УРЬДЧИЛГАА	46,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	92,830.8	97,143.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	344,949.5	2,027,362.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	344,949.5	2,027,362.6
39200	Биет хөрөнгө	344,949.5	535,606.8
39300	Биет бус хөрөнгө	0.0	1,491,755.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	721,900.9	2,348,374.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,500.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,500.2
41300	Өглөг	0.0	1,500.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	721,900.9	2,346,874.2
51	Засгийн газрын хувь оролцоо	721,900.9	2,346,874.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	108,348.0	108,348.0
51200	Хуримтлагдсан үр дүн	604,652.8	2,229,626.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	721,900.9	2,348,374.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,653,748.7	6,884,308.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,739.6	1,625,911.0
120	Нийтлэг татварын бус орлого	53,884.2	1,612,857.4
122	Тусламжийн орлого	24,855.4	13,053.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,575,009.1	5,258,397.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,319,052.0	5,259,334.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,319,052.0	5,259,334.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,216,762.2	5,118,821.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,548,326.7	2,906,805.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,962.7	359,621.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,378.7	159,909.3
2104	Хангамж, бараа материалын зардал	257,078.0	417,203.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	39,156.1
2107	Томилолт, зочны зардал	268,413.9	397,852.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	349,826.6	322,665.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	490,775.6	515,607.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,289.8	140,513.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	334,696.7	1,624,973.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	508.8	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	334,187.9	1,624,973.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,697,764.3	5,452,328.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,054.2	98,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	43,054.2	98,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,654,710.1	5,354,328.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,513,027.3	5,379,128.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,513,027.3	5,379,128.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,356,242.2	5,218,434.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,639,417.6	2,907,122.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,210.7	361,958.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,478.7	149,809.3
2104	Хангамж, бараа материалын зардал	182,799.6	337,500.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	318,165.2
2107	Томилолт, зочны зардал	292,388.2	397,852.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,909.4	344,549.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	557,038.1	401,476.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,785.1	160,694.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	184,737.0	73,200.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	141,682.8	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	141,682.8	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	141,682.8	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-141,682.8	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	43,054.2	73,200.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	43,054.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,054.2	116,254.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	387,713.0	387,713.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,713.0	387,713.0
9	Тайлант үеийн үр дүн	334,187.9	334,187.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,900.9	721,900.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,900.9	721,900.9
19	Тайлант үеийн үр дүн	1,624,833.3	1,624,973.3
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,346,734.2	2,346,874.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,040,998,400.00	4,997,332,503.01	43,665,896.99	99.1
УРСГАЛ ЗАРДАЛ	5,040,998,400.00	4,997,332,503.01	43,665,896.99	99.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,961,776,900.00	4,918,197,974.01	43,578,925.99	99.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,930,232,200.00	2,898,476,367.64	31,755,832.36	98.9
Үндсэн цалин	1,646,437,500.00	1,577,388,491.18	69,049,008.82	95.8
Нэмэгдэл	918,389,500.00	661,398,965.28	256,990,534.72	72.0
Унаа хоолны хөнгөлөлт	285,120,000.00	276,146,191.30	8,973,808.70	96.9
Урамшуулал	80,285,200.00	284,653,636.55	(204,368,436.55)	354.6
Гэрээт ажлын хөлс	-	98,889,083.33	(98,889,083.33)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,278,700.00	360,885,500.41	5,393,199.59	98.5
Тэтгэврийн даатгал	249,069,700.00	248,691,020.20	378,679.80	99.8
Тэтгэмжийн даатгал	29,302,200.00	29,257,767.04	44,432.96	99.8
ҮОМШӨ-ний даатгал	23,441,700.00	23,300,613.62	141,086.38	99.4
Ажилгүйдлийн даатгал	5,860,400.00	5,193,503.32	666,896.68	88.6
Эрүүл мэндийн даатгал	58,604,700.00	54,442,596.23	4,162,103.77	92.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,810,000.00	149,809,340.00	660.00	100.0
Байрны түрээс	149,810,000.00	149,809,340.00	660.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	322,435,100.00	321,427,874.39	1,007,225.61	99.7
Бичиг хэрэг	30,705,700.00	30,705,700.00	-	100.0
Тээвэр, шатахуун	155,309,800.00	155,309,800.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,083,200.00	37,089,460.39	993,739.61	97.4
Ном, хэвлэл	77,870,300.00	77,856,814.00	13,486.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,466,100.00	20,466,100.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	318,565,000.00	318,165,172.00	399,828.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	242,873,800.00	242,873,562.00	238.00	100.0
Тавилга	20,800,000.00	20,800,000.00	-	100.0
Урсгал засвар	54,891,200.00	54,491,610.00	399,590.00	99.3
Томилолт, зочны зардал	372,882,100.00	372,882,100.00	-	100.0
Гадаад албан томилолт	145,643,600.00	145,643,600.00	-	100.0
Дотоод албан томилолт	227,238,500.00	227,238,500.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,709,300.00	185,579,206.50	130,093.50	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,601,600.00	166,475,605.29	125,994.71	99.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,720,000.00	13,715,979.21	4,020.79	100.0
Газрын төлбөр	5,387,700.00	5,387,622.00	78.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	315,864,500.00	310,972,413.07	4,892,086.93	98.5
Бараа үйлчилгээний бусад зардал	37,900,000.00	37,896,115.87	3,884.13	100.0

Хүний эрхийн үндэсний комиссын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	277,964,500.00	273,076,297.20	4,888,202.80	98.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,221,500.00	79,134,529.00	86,971.00	99.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,600,000.00	27,600,000.00	-	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	27,600,000.00	27,600,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	51,621,500.00	51,534,529.00	86,971.00	99.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,621,500.00	51,534,529.00	86,971.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,040,998,400.00	4,997,332,503.01	43,665,896.99	99.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,040,998,400.00	4,997,332,503.01	43,665,896.99	99.1
Улсын төсвөөс санхүүжих	5,040,998,400.00	4,997,332,503.01	43,665,896.99	99.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	165.00	151	14	91.5
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	82	75	7	91.5
Удирдах ажилтан	7	7	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	66	59	7	89.4
Үйлчлэх ажилтан	9	9	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82	75	7	91.5
Ажлын албаны албан хаагч (АА)	66	59	7	89.4
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		313,417,311.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ		313,417,311.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		293,235,973.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		8,646,266.11
210105	Гэрээт ажлын хөлс		8,646,266.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,072,903.89
210201	Тэтгэврийн даатгал		1,072,903.89
2104	Хангамж, бараа материалын зардал		16,072,500.00
210401	Бичиг хэрэг		1,300,000.00
210404	Ном, хэвлэл		14,772,500.00
2107	Томилолт, зочны зардал		24,970,000.00
210702	Дотоод албан томилолт		24,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		158,970,123.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		158,970,123.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		83,504,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		83,504,180.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		20,181,338.55
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		20,181,338.55
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		20,181,338.55
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		313,417,311.56
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		313,417,311.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		313,417,311.56

3. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 302.4 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн данснаас 302.3 сая төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг бүртгэхдээ өглөгийн дансаар дамжуулан давхар бичилт хийлгээгүй	1	302.3			1	302.3	1	302.3				
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг бүртгэлд аваагүй, хоорондын тооцоо үүсгээгүй байна.	1	0.1	1	0.1			1	0.1				
Дүн	2	302.4	1	0.1	1	302.3	2	302.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 124.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 77.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 47.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<p>Тайлант онд үр ашиггүй зарцуулалттай холбоотой дараах ажил гүйлгээнүүд гарсан байна.Үүнд:</p> <p>-Тээвэр шатахууны зардлаас хүний эрхийн үндэсний комиссын дарга болон гишүүдийн дуудлагын тээврийн хэрэгсэл ашигласны илүү цагийн төлбөрт нийт 7.6 сая төгрөг;</p> <p>-Урсгал төсвийн зардлаас авто тээврийн хэрэгслийн гаржийн төлбөрт 1.3 сая төгрөг, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний уулзалт хэлэлцүүлэгт 2.0 сая төгрөг, нийт 3.3 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	1	11.0			1	11.0						
<p>Тайлант онд нийт 69.5 сая төгрөгийн ном хэвлэл, тараах материалуудыг нэр төрөл, ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт хийгээгүй, шууд худалдан авалт хийсэн.</p>	1	69.5			1	69.5						
<p>Цалин хөлсний зардлын бүрэлдэхүүний гэрээт ажлын хөлснөөс гуравдагч этгээдтэй байгуулсан ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 36.0 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	1	36.0					1	36.0				
<p>Төсөл, хөтөлбөрийн гэрээг хийхдээ үлдэгдэл санхүүжилтийг гэрээний ажил бүрэн дууссаны дараа олгоно гэж зааснаас Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй "Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавхжуулах нь"</p>	1	8.2					1	8.2				

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төслийн 2023 оны санхүүжилтээс 8.2 сая төгрөгийг ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын "Хоригдлын хөдөлмөрийн судалгаа" төслийн зарцуулалтад ашигласан байна.												
Дүн	4	124.7			2	80.5	2	44.2				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 800.5 сая төгрөгийн 3, зарлагын 171.2 сая төгрөгийн 16 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна	1	-			1	-
Дүн	1	-			1	-